

MERIT ТӨСЛИЙН МЭДЭЭ

2020 оны 4-р сар | Сэтгүүл №2

MERIT төслийн тайлан төлөвлөгөө танилцуулах уулзалт

2020 оны 4 дүгээр сар

MERIT төсөл нь хамтран ажилладаг аймгуудын удирдлагуудтай 2020 оны 4 дугаар сарын 17-ны өдөр цахим хэлбэрээр уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтад Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Хөгжлийн хөтөлбөрийн ажилтан төслийн орон нутгийн хамтрагч байгууллагууд болох Дорнод, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн Засаг дарга, төлөөллүүд уригдан оролцсон байна.

Хурлын үеэр хүрэлцэн ирсэн зочид, төлөөллүүд MERIT төслийн 2019/2020 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг дүгнэж, 2020/2021 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцлээ. Үүнд техник, технологийн үр өгөөжийг ашиглан зайн сургалтын аргачлалыг түлхүү хэрэглэх, орон нутгийн бүх түвшний удирдлагуудын манлайллын чадварыг бэхжүүлж, үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээг үнэлгээг нэвтрүүлэх талаарх сургалт, зөвлөгөөг авах зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна. Түүнчлэн хүрэлцэн ирсэн зочид, төлөөллүүд төслийн зүгээс одоогийн нөхцөл байдалд дасан зохицож, бүтээлчээр хандаж сургалт, зөвлөмжөө цахим сургалтын арга барилд шилжүүлж, үйл ажиллагаагаа үр бүтээлтэйгээр урагшлуулж байгааг онцолж хэллээ.



Хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ

2020 оны 2 дугаар сар

MERIT төсөл 2020 оны 2 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагч нарт хөгжлийн бодлого төлөвлөлт хийх ерөнхий зарчим, хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг боловсруулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээг үндэсний зөвлөлтэй хамтран хүргэлээ.

Тус зөвлөх үйлчилгээгээр Дундговь аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийг Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулав. Түүнчлэн аймгийн Уул уурхай, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төслийг дээрх хууль, журамд нийцүүлэн боловсруулах талаар холбогдох зөвлөмжийг өгөв. Сургалтын дараа Засаг даргын Тамгын газрын албан хаагчид олж авсан мэдлэгээ практикт хэрэгжүүлж дээр дурьдсан шинэчлэн боловсруулсан Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он/ болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг салбар салбарын төлөөллийг хамруулан хэлэлцүүлж, аймгийн ИТХ-д танилцуулан батлуулахаар төлөвлөж байна.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэх нь

2020 оны 3 дугаар сар

MERIT төслийн зүгээс Үндэсний хөгжлийн газартай төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх чиглэлээр зөвлөгөө, чиглэл өгч хамтран ажиллаж байна.

Стратеги төлөвлөлтийн чиглэлээр арвин туршлагатай техникийн зөвлөх Френк Поттер нь тус газрын Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хариуцан ажилладаг Судалгаа шинжилгээний газрын албан хаагчдад Үр дүнд суурилсан удирдлагын талаар цахим сургалт хүргэж байна.

Сургалт нь үр дүнд суурилсан үнэлгээний аргачлалыг ашиглан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, цаашид уг арга аргачлалыг хэрэглээнд нэвтрүүлэх зорилготой.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор нэн тэргүүнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд бөгөөд эдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлнэ.

Албаг хаагчийн гүйцэтгэлийг байгууллагын зорилт, үйл ажиллагаатай уялдуулах нь

2020 оны 3 дугаар сар

MERIT төслийн зөвлөх Виллиам Гау 2018 оноос хойш Монгол Улсад нийт 7 сарын хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд төслийн хамтрагч байгууллагуудтай зэрэг харилцаа холбоо тогтоож, хамтран ажилладаг туршлагатай зөвлөхүүдийн нэг юм. Вилийн ажлын арга барил, мэдлэг, туршлага нь хамтрагч байгууллагууд төдийгүй Төрийн албан зөвлөлд үнэлэгдэн цаг үеийн нөхцөл байдлаас үл шалтгаалан цахим хэлбэрээр ажиллаж байна.


Зөвлөх төслийн орон нутгийн хамтрагч байгууллагын албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн албан хаагчдийн гүйцэтгэлийг үр дүнтэй удирдах арга барил эзэмшүүлэхийг зорин Дундговь, Дорнод, Сүхбаатар, Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хариуцсан албан хаагч нарт цахим менторинг хийж байна.

Дундговь аймагт Хүний нөөцийн бодлого боловсруулахад шаардлагатай суурь судалгаа хийж байна

2020 оны 4 дүгээр сар

Дундговь аймгийн хэмжээнд Хүний нөөцийн хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулахад шаардагдах суурь үзүүлэлтүүд, өнөөгийн нөхцөл байдлаг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор MERIT төсөл, Дундговь аймгийн ЗДТГ болон Y&R судалгааны байгууллага хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн хүний нөөцийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, албан хаагчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж бодлого, хөтөлбөр боловсруулахад суурь судалгааг тоон болон чанарын аргаар хийж гүйцэтгэнэ.

Уг судалгаа нь тус аймгийн хүний нөөцийг чадавхжуулах, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болно. Түүнчлэн энэхүү судалгаа нь орон нутгийн хэмжээнд жишиг болохоуц бодлого, хөтөлбөр боловсруулах сайн туршлага болно гэж үзэж байна.



Зөрчлийг үр дүнтэй удирдаж байгууллагын гүйцэтгэл, бүтээмжийг нэмэгдүүлэх нь

2020 оны 3 дугаар сар

MERIT төслийн техникийн зөвлөх Бен Зиеглер нь Маргаан шийдвэрлэлт, эвлэрүүлэн зуучлалаар мэргэшсэн ба 3 дугаар сард Монгол Улсад биечлэн ирж ажиллахаар төлөвлөж байсан ч КОВИД-19 вирусийн тархалт нэмэгдэж, олон улсын нислэг, иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж эхэлсэн тул цахимаар ажиллаж байна. MERIT төсөл нь үүссэн нөхцөл байдалд үйл ажиллагаагаа уялдуулахын зэрэгцээ хамтрагч байгууллагуудад төлөвлөгөөт сургалт, зөвлөн туслах үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэхийг зорин ажиллаж байна.

Бен зөвлөх нь үүссэн нөхцөл байдалд тохируулан ажлын төлөвлөгөө, чиглэлд уян хатан байдлаар шуурхай өөрчлөлтийг хийн, зөрчилдөөний удирдлага, эвлэрүүлэн зуучлах чиглэлээр Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газартай хамтран ажиллаж байна. Энэ чиглэлээр тус газрын албан хаагчдын мэдлэг ойлголт нэмэгдсэнээр ажлын байран дахь зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэн шийдвэрлэх зэрэг асуудлаар төрийн бусад байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх боломж бүрдэх юм. Зөрчилдөөнийг үр дүнтэй удирдаж шийдвэрлэсэнээр төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангахад нөлөө үзүүлэхээс гадна байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр дүн, ил тод байдлыг нэмэгдүүлэн, төрийн албаны нэр хүндийг сахин хамгаалах, бэхжүүлэх давуу талтай.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ



Монгол Улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нейшнл Таймс Ньюс Тауэр,
3-р давхар



info@merit.mn



www.merit.mn



+976 7016-5000



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

MERIT төсөл нь Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр болон Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (WUSC) хоорондын түншлэлээр хэрэгжиж байна.